

Тулгарсан довтолгоон ба гуравдагч этгээдийн аргагүй хамгаалалт хийх эрхтэй холбоотой шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ*

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ДЭРГЭДЭХ ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН АКАДЕМИ*

- * Энэхүү дүн шинжилгээ нь Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн албан ёсны цахим хуудаст 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдөр нийтлэгдсэн болно.
- * Энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн Шүүхийн судалгааны төвийн дарга Б.Дөлгөөн (Ph.D) удирдаж, Эрүүгийн эрх зүйн секторын судлаач Ц.Баасанцэрэн гүйцэтгэсэн болно.

УДИРТГАЛ

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулсан боловч нийгэмд ашигтай үйлдлийг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд хамааруулан авч үздэг. Гэмт хэргийн үгүйсгэх нөхцөл байдлын нэг болох аргагүй хамгаалалт нь бусдад гэм хор учруулдаг санаатай бөгөөд идэвхтэй үйлдэл хэдий ч өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалахын тулд хийгдсэн байдаг учир гэмт хэргийн шинжийг агуулдаггүй.¹

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт² "өөрийн, эсхүл бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг хууль бус ба тулгарсан довтолгооны эсрэг хийсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй" хэмээн аргагүй хамгаалалтын талаар хуульчилжээ. Гэвч шүүхийн практикаас харвал, аргагүй хамгаалалтын шинжийг ялгаатай байдлаар тайлбарлан хэрэглэж байгаа нь ажиглагдлаа. Тодруулбал, аргагүй хамгаалалт хийх эрхтэй субъект болон аргагүй хамгаалалтын нэг шинж болох тулгарсан довтолгоон гэдгийг ялгаатай байдлаар тайлбарлаж байна.

Иймд энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээгээр аргагүй хамгаалалтын талаар шийдвэрлэсэн УДШ-ийн тогтоолыг сонгон авч, гуравдагч этгээдийн бусдыг хамгаалах зорилгоор аргагүй хамгаалалт хийх эрхтэй эсэх, "бусад" гэдэгт хэнийг ойлгох мөн аргагүй хамгаалалтын нэг шинж болох тулгарсан довтолгоон гэх ойлголтыг Монгол Улс болон Канад Улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хэрхэн тайлбарлан хэрэглэж байгааг харьцуулан судалж, дүгнэлт өгөхийг зорилоо.

НЭГ. ТАНИЛЦУУЛАХ ХЭСЭГ

Шүүхийн шийдвэрийн дугаар: 272³

Шүүхийн шийдвэрийн огноо: 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгож шийдвэрлэсэн.

Хэргийн тухай товч: Хохирогч согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ хутга хэрэглэн Д.Б рүү довтлох үед шүүгдэгч нь түүнийг тонгорч унаган эрүүл мэндэд нь хүндэвтэр хохирол учруулсан гэмт хэрэгт холбогджээ.

1 Лувсангийн Бат-Очир, *Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги*, (Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2020), 284 дэх тал.

2 *Төрийн мэдээлэл эмхэтгэл*: 2016 он, №07.

3 Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

https://shuukh.mn/single_case/3023?daterange=2020-01-01%20-%202026-02-13&id=3&court_cat=2&bb=1



ХОЁР. ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Анхан шатны шүүх:⁴ Хохирогч нь шүүгдэгчийн эсрэг түүний эрхэд халдсан ямар нэгэн үйлдэл хийгээгүй буюу хууль бус үйлдэл хийснийг тэрээр таслан зогсоох зорилгоор аргагүй хамгаалалт хийх эрх үүсээгүй байна. Өөрөөр хэлбэл хохирогч нь шүүгдэгчид бодитой хүч хэрэглэсэн үйлдэл хийгээгүй ба биед хор хохирол учрах, эсхүл хор хохирол учруулах бодитой шууд аюул тулгарах нөхцөл байдал бий болгосны улмаас эсэргүүцэн довтолсон нөхцөл байдал бий болоогүй, харин шүүгдэгчийн санаатай чиглэсэн үйлдлийн улмаас хохирогчийн биед хүндэвтэр хохирол учирсан үйлдлийг аргагүй хамгаалалт хийх үндэслэл болсон гэж үзэх боломжгүй гэж дүгнэж шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож 240 цагийн хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгэж шийдвэрлэсэн.

Давж заалдах шатны шүүх:⁵ Эрүүгийн хуулийн 4.1 дүгээр зүйлд зохицуулсан аргагүй хамгаалалтыг бусдын хууль бус халдлага эхэлсэн, эхлэх гэж байгаа нь тодорхой болсон үед хийсэн байхыг хуульд нарийвчлан тодорхой заасан байдаг. Хохирогчийн хутга далайж буй үйл явцыг шүүгдэгч рүү чиглэсэн довтолгоон эхэлсэн гэж үзэхгүй. Хутга далайсан байх үед нь шүүгдэгч тонгорч унагаан хүндэвтэр гэмт учруулсан байна гэж дүгнэж шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн гаргасан давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Хяналтын шатны шүүх: Хохирогч хутга хэрэглэн довтолсон гэмт үйлдлийг өөр хэн нэгэн хүн хөндлөнгөөс таслан зогсоож, аргагүй хамгаалалт хийх эрхтэй гэж үзнэ. Шүүгдэгч нь хохирогчийг согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ хутга хэрэглэн, хутгатай гараа далайж Д.Б-ийн амь нас, эрүүл мэндэд аюултай аргаар заналхийлж довтлох үед тонгорч унагасан үйлдэл нь хохирогчийн илтэд буруутай, хууль бус үйлдлийг таслан зогсоох зорилго агуулсан байна гэж дүгнэж анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх тогтоол, магадлалыг хүчингүй болгож, шүүгдэгчид холбогдох Эрүүгийн хуулийн 11.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгасан.

ГУРАВ. ДҮН ШИНЖИЛГЭЭ

3.1. Гуравдагч этгээд аргагүй хамгаалалт хийх эрхтэй эсэх

а) Эрх зүйн зохицуулалт болон онолын ойлголт

Эрүүгийн хуулиар хамгаалагдсан төр, нийгмийн ашиг сонирхол, өөрийн болон бусдын амьд явах, халдашгүй чөлөөтэй байх, түүнчлэн бусад эрх, эрх

4 Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: https://shuukh.mn/single-case/54636?daterange=2021-03-01%20-%202021-03-31&id=1&court_cat=2&bb=1

Баянхонгор аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 2021/ШЦТ/061 дугаар шийтгэх тогтоол. (Сүүлд үзсэн: 2026.02.16)

5 Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: https://shuukh.mn/single-case/12672?daterange=2021-04-19%20-%202021-04-21&id=2&court_cat=2&bb=1

Баянхонгор аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 2021/ДШМ/033 дугаар магадлал.



чөлөөг нийгэмд аюултай халдлагаас хамгаалахдаа Эрүүгийн хуульд заасан үйлдлийг хийж, халдагч этгээдэд гэм хор учруулсныг аргагүй хамгаалалт гэж үзэн гэмт хэрэгт тооцохгүй.⁶

Хууль зүйн ухааны доктор Т.Золбоо "Гуравдагч этгээд нь довтолгоонд өртөж байгаа этгээдэд тусламж үзүүлэх, хамгаалах гэсэн санаа байдаг учир үүнийг онолын хувьд "аргагүй тусламж" гэж томъёолж" болно⁷ гэжээ. Аргагүй тусламжийн ойлголт нь аргагүй хамгаалалтын ойлголттой үндсэндээ ижил боловч субъект өөрийгөө бус бусад этгээдийн суурь эрхийг хамгаалахтай холбоотой харилцааг хамаарна⁸ гэж тайлбарласан.

Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх аргагүй хамгаалалтын талаарх зохицуулалтын түүхэн уламжлалыг авч үзвэл:

Хүснэгт 1. Аргагүй хамгаалалтын талаарх эрх зүйн зохицуулалт (1926–2002 он)

Эрх зүйн эх сурвалж	Зүйл, заалт
1926 оны Шүүх цаазын бичиг ⁹	22 дугаар зүйл. Өөрийн буюу бусдын амь ба биеийг буюу эрх чөлөөг хамгаалахын тулд үйлдсэн хэрэг нь хэр хэмжээнээс хэтэрсэнгүй бөгөөс ялыг үл хэлэлцэнэ.
1929 оны Шүүх цаазын бичиг ¹⁰	23 дугаар зүйл. Өөрийн буюу бусдын амь бие, эрх чөлөөг хамгаалах, мөн тэрчлэн эдүүгээгийн улс төрийн амгалан байдалд холбогдох аливаа зүйлүүдийг хамгаалахын тулд үйлдсэн хэрэг нь хэр хэмжээнээс хэтрээгүй бөгөөс ял үл хэлэлцмөй.
1934 оны Шүүх цаазын бичиг	7 дугаар зүйл. Ардын хувьсгалт засаг дор халдахаар завдагсдыг ба өөрийн болон бусдын амь нас, бие, эд хөрөнгө, эрх чөлөөнд халдсаныг эрх биш хамгаалахаар үйлдсэн хэрэг нь хэр хэмжээнээсээ хэтрээгүй бол ял үл хэлэлцмөй.
1942 оны Эрүүгийн хууль ¹¹	12 дугаар зүйл. Эрүүгийн хуульд заасан хэргүүдийг үйлдсэн боловч хэрэв тийнхүү үйлдсэн хэрэг нь ардын хувьсгалт засаг төрд халдахыг завдсан буюу эсвэл өөрийн буюу бусдын амь бие, эрх чөлөөнд халдсан явдлаас аргагүй хамгаалахын тулд үйлдсэн хэрэг нь хир хэмжээнээс хэтрээгүй гэж шүүн таслах газраас үзвэл ял үл хэлэлцэнэ.

6 Суурийн Жанцан, *Гэмт хэргийн тухай Эрүүгийн эрх зүйн тулгуур ойлголт*, (Улаанбаатар: Ган принт, 2005), 76 дахь тал.

7 Тогоогийн Золбоо, *Эрүүгийн эрх зүй /Ерөнхий анги/ Гэмт хэргийн бүтээц*, (Удам соёл, 2023), 125 дахь тал

8 *Мөн тэнд*.

9 Батсүхийн Баярсайхан, Суурийн Жанцан, Жамсрангийн Энхнасан, Даваажавын Сумъяацэрэн, *Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911–2009 он)*, (Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2011), 285 дахь тал.

10 *Мөн тэнд*, 315 дахь тал.

11 *Мөн тэнд*, 361 дэх тал.



1961 оны Эрүүгийн хууль ¹²	9 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд заасан үйлдлийг улс орон нийтийн эрх ашиг, өөрийн ба бусдын амь бие, эрүүл мэнд, эрхийг нийгэмд аюултай байдлаас хамгаалахын тулд халдагчид хохирол учруулах замаар үйлдсэн бөгөөд тэр нь аргагүй хамгаалалтын хир хэмжээнээс хэтрээгүй байвал гэмт хэрэгт тооцохгүй.
1986 оны Эрүүгийн хууль ¹³	12 дугаар зүйл. Аргагүй хамгаалалтын байдалд, өөрөөр хэлбэл, улс, нийгмийн эрх ашиг, өөрийн болон бусдын амь бие, эрүүл мэнд, эрхийг нийгэмд аюултай халдлагаас хамгаалахын тулд энэ хуулийн тусгай ангид заасан үйлдлийг халдагчид гэм хор учруулах замаар хийсэн нь аргагүй хамгаалалтын хэр хэмжээнээс хэтрээгүй байвал гэмт хэрэгт тооцохгүй.
Эрүүгийн хууль (2002) ¹⁴	40 дүгээр зүйл. Аргагүй хамгаалалтын байдалд, өөрөөр хэлбэл, энэ хуулиар хамгаалагдсан төр, нийгмийн ашиг сонирхол, өөрийн болон бусдын амьд явах, халдашгүй чөлөөтэй байх, түүнчлэн бусад эрх, эрх чөлөөг нийгэмд аюултай халдлагаас хамгаалахдаа энэ хуулийн тусгай ангид заасан үйлдэл хийж, халдагч этгээдэд гэм хор учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй.

1926 оны Шүүх цаазын бичгээс эхлэн 2002 оны Эрүүгийн хууль дахь зохицуулалтыг харахад өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор аргагүй хамгаалалт хийх эрхтэй хэмээн хуульчилж иржээ. "Бусдын" гэх ойлголтыг тодорхой нэг этгээдээр хязгаарлахгүй, хэн ч байж болох өргөн хүрээтэйгээр тогтоож байжээ. 2002 оны Эрүүгийн хуулийн тайлбарт бусдын амьд явах, халдашгүй чөлөөтэй байх, бусад эрх, эрх чөлөөг нийгэмд аюултай халдлагаас хамгаалах талаар хуульчилсан нь "...хүн бүр бусад хүний амьд явах, амьдрах эрхийг хүндэтгэн сахих эрх, үүргүүдийг цогц байдлаар хуулийн хамгаалалтад оруулсан хэрэг юм"¹⁵ гэж тэмдэглэсэн байхаас харахад хүн бүр бусдын амь нас, эрх, эрх чөлөөг хамгаалахад оролцох боломжтой юм.

Дээрх эрх зүйн эх сурвалжуудаас харахад гуравдагч этгээд бусдын амь нас, эрүүл мэнд, эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор аргагүй хамгаалалт хийх эрхтэй болохыг түүхэн хөгжлийн явцад тогтвортойгоор тусгаж иржээ. Харин 2015 оны Эрүүгийн хуульд дараах хүрээнд тусгажээ.

12 Мөн тэнд, 420 дахь тал.

13 Мөн тэнд, 510 дахь тал.

14 Эрүүгийн хууль (2002)-ийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг.

15 Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, 2013, 129 дэх тал.

**Хүснэгт 2. 2015 оны Эрүүгийн хууль дах зохицуулалт**

2020 оны 01 сарын 10-ны нэмэлт өөрчлөлтөөс өмнөх зохицуулалт	Одоогийн хүчин төгөлдөр зохицуулалт
4.1 дүгээр зүйл. Аргагүй хамгаалалт 1. Өөрийн, ойр дотны хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг хууль бус ба тулгарсан довтолгооны эсрэг хийсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй. "ойр дотны хүн" гэж тухайн хүний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг эх, эмэг эх, төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд, ач зээ, төрсөн ах, эгч, дүү, хамт амьдарч байгаа бусад төрөл, садангийн хүнийг ойлгоно.	4.1 дүгээр зүйл. Аргагүй хамгаалалт 1.Өөрийн, эсхүл бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг хууль бус ба тулгарсан довтолгооны эсрэг хийсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй.

2015 оны Эрүүгийн хуулийн анхны найруулгад уг зохицуулалтыг "өөрийн болон ойр дотны хүний" гэж өөрчлөн, ойр дотны хүнд хэн хамаарахыг нарийвчлан тогтоож, уг зохицуулалтын хамрах хүрээг тодорхой хэмжээнд хумьсан байна.

Хууль тогтоогч аргагүй хамгаалалт хийх эрхийг зөвхөн "ойр дотны хүнээр хязгаарласан нь монголын нийгэмд хар амиа хичээх аминч үзлийг улам бүр дэвэргэж, бусад хүний төлөө, улс, нийгмийн төлөө гэсэн монголчуудын хүнлэг сайхан сэтгэлийг хориглох байдалд хүргэж болзошгүй"¹⁶ гэж Хууль зүйн шинжлэх ухааны доктор С.Нарангэрэл, Хууль зүйн ухааны доктор Ж.Эрдэнэбулган нар "Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж" бүтээлдээ дурджээ. Мөн "хүн хүнээ хайрлах" өвөг дээдсийн олон зуун жилийн сайн сайхан уламжлалыг огоорч, хүний наад захын хүмүүнлэг ёсны хэм хэмжээ, хүнлэг чанарын хүлээс болжээ. Энэ нь бусдыг аюулаас хамгаалах ямар ч боломжгүй нөхцөл байдал үүсч байна. Жишээлбэл, сүйт залуудаа зодуулж байхад цагдаа ирэхийг эсвэл зодож дуусахыг нь хүлээхээс өөр аргагүй болно"¹⁷ гэж эрдэмтэн, судлаачид уг зохицуулалтад шүүмжлэлтэй хандаж байв.

Харин 2020 оны нэмэлт, өөрчлөлтөөр уг заалтыг өөрчилж "өөрийн болон бусдын" гэж илүү өргөн хүрээгээр тогтоож, гуравдагч этгээд аргагүй хамгаалалт хийх эрхтэй болохыг Эрүүгийн хуулиар баталгаажуулсан байна.

б) Төсөөтэй шүүхийн шийдвэр

Дүн шинжилгээний энэ хэсэгт гуравдагч этгээдийн аргагүй хамгаалалт хийх эрхтэй холбоотой хяналтын шатны шүүхийн тогтоолыг авч үзэв.

16 Содовсүрэнгийн Нарангэрэл, Жуужаагийн Эрдэнэбулган, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж*, (Улаанбаатар: Соёмбо принтинг, 2019), 173 дахь тал.

17 Ё.Бямбацэрэн "Аргагүй хамгаалалт уу, хууль ёсны хамгаалалт уу..." *Монголын төр, эрх зүй* 2(84), 2016, 14 дэх тал, <https://e-library.num.edu.mn/cgi-bin/koha/opac-ISBDdetailbook.pl?biblionumber=141271> (Сүүлд үзсэн: 2026.04.24)



Улсын дээд шүүхийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 107 дугаар тогтоол¹⁸

Хэргийн тухай товч: П.А нь хохирогчийн нүүрэн тус газарт цохиж, эрүүл мэндэд нь хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэгт холбогджээ.

Шүүхийн шийдвэр, үндэслэл: Прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэн, шүүхэд шилжүүлсэн.

Анхан шатны шүүхээс гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож П.А-г цагаатгаж шийдвэрлэсэн.

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн цагаатгах тогтоолыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

Хяналтын журмаар гаргасан прокурорын эсэргүүцэлдээ: "...Аргагүй хамгаалалт нь илэрхий, хүч хэрэглэсэн довтолгооны үед төдийгүй, довтолсон болон илэрхий заналхийлэл хийгдсэн үеэс үүсэх бөгөөд эрүүл мэндийн эсрэг хууль бус ба тулгарсан довтолгооны эсрэг халдагч этгээдийн хууль бус үйлдлийг таслан зогсоох зорилгоор үйлдэгдэж буй хариу үйлдэл тогтоогдоогүй байхад аргагүй хамгаалалт гэж хэргийн нөхцөл байдлын талаар буруу дүгнэлт хийсэн.

Хавтаст хэрэгт авагдсан мэдүүлгийн нотлох баримтуудад бодитой үнэлэлт дүгнэлт өгөлгүй, зөвхөн хохирогчийн довтолгоо дуусаагүй мэтээр буруу дүгнэлт хийн хэргийг хэрэгсэхгүй болгосон гэж үзэхээр байна. Эдгээр нотлох баримтуудаар шүүгдэгч П.А- нь Б.Д-ий эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал тогтоогдож байна. Иймд анхан шатны шүүхийн цагаатгах тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгуулж, анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцааж өгнө үү гэжээ.

Хяналтын шатны шүүхээс анхан шатны шүүхийн тогтоолыг хэвээр үлдээж, прокурорын эсэргүүцлийг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

Шийдвэрийн үндэслэл нь: Аргагүй хамгаалалт нь халдагч этгээдийн хууль бус, тулгарсан довтолгооны эсрэг өөрийн, эсхүл бусдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах санаа зорилгоор хариу довтолгоон хийж, халдагч этгээдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж буй гэмт халдлагаас хувь хүн өөрийгөө хамгаалах эрхийг баталгаажуулж гэмт явдалтай тэмцэхэд иргэдийн идэвхтэй оролцоог дэмжих байдлаар нийгмийг илүү аюулгүй, амар тайван байдлыг бүрдүүлэхэд чиглэсэн хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа юм.

Хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тухайн хэрэгт гэрч Н.З, шүүгдэгч П.А нарын хооронд үүссэн маргаанд хохирогч гэх Б.Д нь хөндлөнгөөс оролцон П.А-д довтолж, улмаар тэднийг салгахаар очсон П.А-гийн эхнэр Б.О-д ч халдсан байна. Энэ үед П.А нь эхнэрээ болон өөрийгөө хамгаалан хохирогчид хөнгөн гэмтэл учруулсан үйлдлийг аргагүй хамгаалалтын хүрээнд хийгдсэн байна гэж шүүх бүрэлдэхүүн үзэв.

Дээрх хэрэгт хохирогч нь шүүгдэгч болон маргаанд хөндлөнгөөс оролцсон түүний эхнэрт халдсан бөгөөд шүүгдэгч нь өөрийн болон эхнэрийнхээ аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор хариу үйлдэл хийсэн. Шүүх уг үйлдлийг хохирогчийн хууль бус, тулгарсан довтолгоог таслан зогсоох зорилгоор аргагүй хамгаалалт хийсэн гэж үзэн цагаатгаж шийдвэрлэсэн. Эндээс аргагүй хамгаалалт нь зөвхөн өөрийгөө хамгаалах хүрээгээр хязгаарлагдахгүй харин бусдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хэрэгжих боломжтой нь харагдаж байна. Гуравдагч этгээдийг хамгаалах зорилго нь нийгэмд гэмт халдлагыг таслан зогсооход иргэдийн оролцоог хамруулж буй нэг хэлбэр болохыг тэмдэглэжээ.

18 Улсын дээд шүүхийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 107 дугаар тогтоол, https://shuukh.mn/single_case/3468?daterange=2020-01-01%20-%202026-02-25&id=3&court_cat=2&bb=1



3.2. Тулгарсан довтолгооны талаарх ойлголт

а) Эрх зүйн зохицуулалт болон онолын ойлголт

Аргагүй хамгаалалт хийх гол үндэслэл нь эсрэг этгээдийн довтолгоон, халдлага болдог. **Халдлага гэдэг нь** өргөн хүрээг хамардаг ойлголт бөгөөд ямар ч гэмт хэрэг үйлдэгдэх үед илэрдэг¹⁹ бөгөөд хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхолд заналхийлсэн үйлдэл юм. **Довтолгоон гэдэг нь** өөрийн үйлдлийг удирдаж, ухамсарлаж байгаа боловч бусдыг гэмтээх, аюул учруулахуйц үйлдэл гаргахыг ойлгох юм.²⁰ Довтолгоон нь халдлагын нэг төрөл бөгөөд аргагүй хамгаалалтын объектив талд заавал довтолгоон байх ёстой бөгөөд тухайн довтолгоон нь хууль бус мөн бодитой байх шинжийг агуулсан байх ёстой.²¹

2007 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйл /Аргагүй хамгаалалт/-ийг зөв хэрэглэх тухай Монгол Улсын дээд шүүхийн зөвлөмж²²-д "Халдлага бодитой хийгдсэн, эсхүл хийгдэх нь тодорхой болсон тохиолдолд төр, нийгмийн ашиг сонирхол, өөрийн болон бусдын амьд явах, халдашгүй чөлөөтэй байх, түүнчлэн бусад эрх, эрх чөлөөг түүнээс хамгаалж хийсэн үйлдлийн улмаас халдагч этгээдэд учирсан хохирлын хэмжээг үл харгалзан хамгаалагч этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж байвал зохино" гэж тэмдэглэжээ.

Аргагүй хамгаалалт хийх талаар 2002 оны Эрүүгийн хуульд нийгэмд аюултай халдлага гэж тодорхойлж байсан бол 2015 онд шинэчлэн найруулж баталсан Эрүүгийн хуульд хууль бус ба тулгарсан довтолгооны эсрэг хийх шаардлага тавигдах болсонд судлаачид шүүмжлэлтэй хандсан юм. Тухайлбал, эрүүгийн хуулиар аргагүй хамгаалалт хийх эрхийг зөвхөн довтолгооноор хязгаарлаж, угтаа амь насанд аюултай хүч хэрэглэхээр бодитой заналхийлэх тохиолдолд гэм буруутай этгээдэд гэм хор учруулсан бол аргагүй хамгаалалт гэж тооцохоо больсон байна.²³ Мөн Эрүүгийн хуульд заасан хууль бус довтолгоо гэсэн нь хэт хэлбэрийн шинжийг агуулсан талаар дурджээ.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулиар халдлага гэснийг халж, хууль бус довтолгоо гэж тодорхойлсон нь "заналхийлэх" үйлдэл нь бие даасан гэмт хэрэг болж хуульчлагдсантай холбоотой байж болох юм. Учир нь бусад этгээдээс амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн үйлдэл гаргавал эрх бүхий байгууллагад хандаж, гэм буруутай нь тогтоогдвол эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой. Харин аргагүй хамгаалалт хийх эрхийг бусад этгээдээс заавал хууль бус довтолгоо эхлэх гэж байгаа, эхэлсэн үргэлжилж байгаа, довтолгоо төгсөөгүй байх шинжүүд хамаарах юм.²⁴

19 *Дам эшлэл*: Г.Эрдэнэчимэг, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх аргагүй хамгаалалт, Хууль зүйн магистрын диссертаци, Монгол Улсын Их Сургууль, 2016, 9 дэх тал <https://e-library.num.edu.mn/cgi-bin/koha/opac-detail.pl?biblionumber=127942> (Сүүлд үзсэн: 2026.04.24)

20 Содовсүрэнгийн Нарангэрэл, Жуужаагийн Эрдэнэбулган, *өмнөх эшлэл* 15, 174 дэх тал.

21 Г.Эрдэнэчимэг, *өмнөх эшлэл* 17, 9 дэх тал

22 Монгол Улсын дээд шүүхийн зөвлөмж: Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйл /Аргагүй хамгаалалт/-ийг зөв хэрэглэх тухай (2007), <http://old.supremecourt.mn/act/print/208>

23 Содовсүрэнгийн Нарангэрэл, Жуужаагийн Эрдэнэбулган, *өмнөх эшлэл* 15, 174 дэх тал.

24 Дансрангийн Отгонбаяр, *Аргагүй хамгаалалтын эрүүгийн эрх зүйн зохицуулалт, практик хэрэглээ*, Хууль зүйн магистрын диссертаци, Монгол Улсын Их Сургууль, 2024, 21–22,



Аргагүй хамгаалалт хийх объектив талын шинжийн нэг бол довтолгоон бодитой байх явдал юм. Довтолгоон бодитой байна гэдэг нь довтолгоон шууд эхлэх гэж байгаа нь тодорхой болсон, эхэлсэн эсвэл эхлээд үргэлжилж байхыг хэлнэ. Довтлогч этгээдийн үйлдэл хүний амь нас, эрүүл мэндэд бодитой аюул учруулах боломжтой болсон үеэс довтолгоон эхлэх нь тодорхой болсон гэж үзнэ.²⁵ Нийгэмд аюултай халдлага (довтолгоон) нэгэнт эхэлсэн буюу халдлагын явцад түүний эсрэг аргагүй хамгаалалт хийж болох нь эргэлзээгүй. Харин ч зайлшгүй хийгдэх хууль ёсны баталгаатай үйлдэл гэж үзэх ёстой. Жишээ нь, довтлогч этгээд хутга далайн сүрдүүлж эд хөрөнгө өгөхийг шаардаж байгаа эсвэл хулгайч этгээд бусдын халаасанд гараа оруулсан үед аргагүй хамгаалалтын үйл ажиллагааг хийж болно.²⁶

Эндээс дүгнэвэл довтолгоо нэгэнт эхэлсэн, дуусаагүй буюу үргэлжилж байгаа, эсвэл довтолгоо эхлэх нь илэрхий, тодорхой болсон нөхцөл байдлыг тулгарсан довтолгоон гэж үзэхээр байна. Дүн шинжилгээний хүрээнд хөндөгдөж буй "хутга хэрэглэн довтолсон" үйлдлийн хувьд Улсын дээд шүүхийн 2023 оны 06 сарын 30-ны өдрийн 109 дугаар тогтоолд²⁷ "... хутга бариад "ална" гэж хашгираад орж ирсэн нөхцөл байдал нь тулгарсан довтолгоо мөн" гэж дүгнэжээ.

б) Төсөөтэй шүүхийн шийдвэр

Дүн шинжилгээний энэ хэсэгт тулгарсан довтолгооныг тодорхойлсон давж заалдах шатны шүүхийн магадлалын үндэслэлийг авч үзэв.

<https://e-library.num.edu.mn/cgi-bin/koha/opac-detail.pl?biblionumber=142307> (Сүүлд үзсэн: 2026.04.24)

25 Тогоогийн Золбоо, өмнөх эшлэл 6, 120 дахь тал.

26 Г.Энхтайван, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх Аргагүй хамгаалалт, 2003, 25, <https://e-library.num.edu.mn/cgi-bin/koha/opac-ISBDdetailbook.pl?biblionumber=135454> (Сүүлд үзсэн: 2026.04.24)

27 Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://legaldata.mn/shiidver/eruu/view/3247?whr=s>

Улсын дээд шүүхийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 109 дугаар тогтоол. (Сүүлд үзсэн: 2026.03.27)

Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 2022/ДШМ/810 дугаар магадлал²⁸

Хэргийн тухай товч: 2021 оны 07 дугаар сарын 08-ны орой хохирогч С.С нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ Д.Т-ыг "гэрээсээ яв" гээд хутга авч дайрахад нь Д.Т нь түүнийг гараараа нэг удаа нүүрэн хэсэгт цохиж гэмтэл учруулсны улмаас 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдөр амь насыг нь хохироосон буюу хүнийг алах гэмт хэрэгт холбогджээ.

Шүүхийн шийдвэр, үндэслэл: Прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зүйлчлэн яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн.

Анхан шатны шүүхээс Эрүүгийн хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргагүй хамгаалалт хийсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож, Д.Т-ыг цагаатгаж шийдвэрлэжээ.

Прокурорын давж заалдах журмаар бичсэн эсэргүүцэлдээ: "...Талийгаач нь Р20.5 үлдэц шизофрени гэсэн оноштой 1992 оноос эмнэлгийн хяналтад байсан байх боловч, 2014 оноос хойш дээрх өвчний оношоор эмчилгээнд дахин хамрагдаж байсан нь баримтаар тогтоогдоогүй, өөрөөр хэлбэл тэрээр амьдарч байх өөрийн эргэн тойрныхоо амьдралын хэв маягт уг өвчнийхөө шинжээр бусдад танигдаж, ийм араншин гаргаж байсан нөхцөл байдал тодорхой хугацаанд таньж мэдсэн гэх гэрч Б.А, А.Б нарын мэдүүлгээр тогтоогдоогүй, тэдний зүгээс ийм өвчтэй байсныг огт мэддэггүй байсан нь тэдний мэдүүлэг болон бусад баримтаар тогтоогдоно. Шүүхээс талийгаачийг дээрх өвчнийхөө үед ямар үйлдэл, үйл хөдөлгөөн үг хэл гаргадаг, ахуйн хэрэглээндээ ямар төрлийн ямар эд зүйлсийг хэрэглэдэг хэрхэн ямар зан араншин гаргадаг, архи ууж согтсон үедээ ямар байдаг байсан талаар сүүлийн арван жил ханилсан гэрч С.О, 2005 оноос найзалсан шүүгдэгч Д.Т, эмчлэгч бус Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвийн эмч Г.Баярмаагийн дээрх өвчний хүндэрсэн шинжийн талаар тодорхойлж өгсөн мэдүүлгийг үндэслэл болгож шүүгдэгчийг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд буюу аргагүй хамгаалалт хэрэглэсэн гэсэн нь хэргийн жинхэнэ нөхцөл байдалтай нийцээгүй байна. Иймд анхан шатны шүүхийн цагаатгах тогтоолыг хүчингүй болгуулж, хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр улсын яллагчийн эсэргүүцэл бичсэн.

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн цагаатгах тогтоолыг хэвээр үлдээж, прокурорын эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Шийдвэрийн үндэслэл нь: Гэмт хэрэгт холбогдсон этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөөнд халдаж, өдөөн турхирч буй хохирогчийн энэхүү үйлдлийн эсрэг хамгаалалт хийх эрхийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4.1 дүгээр зүйлд хуульчилсан.

Аргагүй хамгаалалтын объектив тал нь довтолгоон байх ёстой бөгөөд довтолгоон нь хууль бус, бодитой байх шинжийг агуулсан байх шаардлагатай. Амь хохирогч нь Д.Т-ын хуулиар хамгаалагдсан халдашгүй чөлөөтэй байх эрхийг ноцтойгоор зөрчиж халдсан зүй бус үйлдэл гаргасан буюу хутга авч идэвхтэй үйлдлээр дайрсан нь довтолгоон эхэлснийг нотолж байх бөгөөд Д.Т нь энэхүү үйлдлээс хамгаалж хариу үйлдэл хийсэн нь "аргагүй хамгаалалт" хийх эрхэд хамаарч байна хэмээн дүгнэжээ.

Дээрх шийдвэрээс харвал хохирогч нь хутга хэрэглэн идэвхтэй үйлдлээр дайрсан нь хамгаалагдаж буй этгээдийн амь нас, эрүүл мэндэд шууд аюул учруулах бодит нөхцөл байдлыг бий болгосон гэж үзэж "хууль бус, бодит довтолгоо" эхэлсэн гэж дүгнэжээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1 дүгээр зүйлийн тайлбарт²⁹ энэ хуульд заасан "зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл" гэж иж бүрдэл, бүтцийн хувьд аливаа биетийг устгах, гэмтээх, бие хамгаалах, дохио өгөх зориулалттай эд зүйл, тоног төхөөрөмж, хэрэгслийг хамааруулж ойлгоно гэж

28 Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 2022/ДШМ/810 дугаар магадлал, https://shuukh.mn/single_case/15372?daterange=2020-01-01%20-%202026-02-25&id=2&court_cat=2&bb=1

29 Эрүүгийн хууль (2015)-ийн 11.1 дүгээр зүйл.



заасан. Энэхүү тайлбарын хүрээнд хутга нь зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлд хамаарна. "Зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл" хэрэглэн довтолох нь аюулын түвшинг ихэсгэдэг учир тулгарсан довтолгоонд хамаарна.

3.3. Гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт

Харьцуулсан судалгааны хүрээнд Канад Улсын эрх зүйн зохицуулалтыг сонгон авч судаллаа.

Канад Улсын хувьд аргагүй хамгаалалтын талаарх ойлголтыг хүнийг хамгаалах (англ. defence of person) болон өмч хамгаалах (англ. defence to property) гэж Эрүүгийн хууль (1985)-ийн 34 болон 35 дугаар зүйлд тусгагдсан. Энэ нь хүний амь нас, эрүүл мэндээс гадна өмч, хөрөнгийг хамгаалах зорилгоор аргагүй хамгаалалт хийх эрхтэйг хуульчилсан онцлог зохицуулалт юм. Хүнийг хамгаалах аргагүй хамгаалалтын талаарх зохицуулалтын хүрээнд дараах байдлаар судлав.

а) Гуравдагч этгээдийн аргагүй хамгаалалт хийх эрхийн талаар

Канад Улсын шүүгч Fred Kaufman болон G.W. Burbidge нар 1889 онд хэвлүүлсэн "Канадын эрүүгийн эрх зүйн хураангуй" бүтээлдээ "Хүн өөрийгөө эсвэл бусдыг хууль бус хүчирхийллээс хамгаалах зорилгоор хүний амь нас, бие махбодид санаатайгаар гэмтэл учруулсан бол гэмт хэрэгт тооцогдох ёсгүй" гэж тэмдэглэсэн бөгөөд үүнийгээ эрүүгийн хуульд тусгахыг зорьсон боловч дэмжигдээгүй байна. Тухайн үеийн эрх зүйн ойлголтоор аргагүй хамгаалалтын эрх нь өөрийгөө, өөрийн гэр бүл, ойрын хүмүүс, өөрийн хамгаалалтад байгаа хүнийг хамгаалах хүрээнд ойлгогдож байжээ.³⁰

Тус улсын Эрүүгийн хууль (1985)-ийн 37 дугаар зүйлд "Хүн өөрийгөө эсвэл өөрийн хамгаалалтад байгаа хүнийг тулгарсан довтолгооноос хамгаалах зорилгоор хүч хэрэглэхдээ тухайн довтолгоо, түүний давтан үйлдлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай хэмжээнээс хэтрүүлээгүй тохиолдолд хууль ёсны үйлдэлд тооцно" гэж заасан. Энэ нь өөрийн хамгаалалтад хамаарахгүй бусад хүнийг хамгаалах үйлдэл хийх эрхгүй зохицуулалт байв. 100 гаруй жил өөрчлөгдөөгүй байсан уг заалтыг Эрүүгийн хуулийн 2012 оны нэмэлт, өөрчлөлтөөр хасаж, 34 дүгээр зүйлд заасан дараах хүрээнд зохицуулжээ.

30 Larry C. Wilson, "The Defence of Others – Criminal Law and the Good Samaritan", McGill Law Journal, 771, <https://lawjournal.mcgill.ca/wp-content/uploads/pdf/548662-wilson.pdf> (last visited Apr.20, 2026)

Хүснэгт 3. Эрүүгийн хуулийн 34 зүйл. Хүнийг хамгаалах³¹**34 дүгээр зүйл.**

1. Дараах нөхцөл бүрдсэн тохиолдолд гэмт хэрэгт тооцохгүй

- a) тухайн хүн өөрийн эсвэл бусдын эсрэг хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн гэж үндэслэлтэйгээр ойлгосон байх;
- b) тухайн үйлдэл нь өөрийгөө эсвэл бусдыг хүч хэрэглэх, заналхийллээс хамгаалах зорилгоор хийгдсэн байх;
- c) тухайн үйлдэл нь тухайн нөхцөл байдалд тохирсон байх.

Үнэлэх хүчин зүйлс:

2. Тухайн үйлдэл нь үндэслэлтэй, тохирсон эсэхийг тогтоохдоо тухайн үйлдэл хийсэн этгээд, бусад оролцогч болон бусад бүх нөхцөл байдлыг шүүх харгалзан үзнэ. Үүнд дараах хүчин зүйлс багтах боловч үүгээр хязгаарлагдахгүй.

- a) хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн байдлын шинж чанар;
- b) хүч хэрэглэх нь гарцаагүй байсан эсэх, өөр арга хэмжээ авах боломж байсан эсэх;
- c) тухайн үйл явдалд оролцсон этгээдийн гүйцэтгэсэн үүрэг, оролцооны байдал;
- d) тухайн үйл явдалд оролцогч талуудын аль нэг нь зэвсэг хэрэглэсэн, хэрэглэхээр заналхийлсэн эсэх;
- e) оролцогч талуудын биеийн хэмжээ, нас, хүйс, бие бялдрын чадвар;
- f) оролцогч талуудын оролцооны байдал, үргэлжилсэн хугацаа болон өмнө нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж байсан эсэх;
- g) оролцогч талуудын өмнөх харилцааны түүх;
- h) тухайн этгээдийн хүч хэрэглэсэн хариу үйлдлийн шинж чанар, зохистой байдал;
- i) тухайн этгээдийн үйлдэл нь хууль ёсны болохыг мэдэж хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн үйлдлийн эсрэг хийгдсэн эсэх.

Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр зөвхөн өөрийгөө, өөрийн хамгаалалтад байгаа хүнийг хамгаалах бус бусад этгээдийг мөн хамгаалах зорилгоор аргагүй хамгаалалт хийх эрхтэй болсон. Бусад этгээд гэдэгт хэн ч хамаарч болох ба үүнд ямар нэг хязгаарлалт тавиагүй байна.³² Гуравдагч этгээдийн эсрэг хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн гэж үндэслэлтэйгээр ойлгосон байх, хамгаалах зорилгоор үйлдэл хийсэн байх, тухайн үйлдэл нь нөхцөл байдалд нийцсэн байх шаардлагатай. 34(2) дугаар зүйлд заасан үнэлэх хүчин зүйлс нь зайлшгүй нөхцөл биш бөгөөд харгалзан үзэх хүчин зүйлс юм. Аргагүй хамгаалалт хийх үндэслэлтэй байсан эсэхийг тогтооход ач холбогдолтой.³³

b) Тулгарсан довтолгооны талаарх ойлголт

Эрүүгийн хуулийн 2012 оны нэмэлт өөрчлөлтөөр "хууль бус довтолгоо" (*англ. unlawfully assaulted*) гэдгийг хасаж оронд нь "хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн" (*англ. use or threat of force*) гэж өөрчилсөн. Учир нь довтолгоогчийн үйлдэл, зорилгыг хэрхэн хүлээн авснаас шалтгаалан хэргийн нөхцөл байдлын талаар дүгнэхэд маргаан ихээхэн үүсдэг байснаас шалтгаалан тухайн нөхцөл

31 Criminal Code (1985), art.34. <https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/c-46/page-5.html#h-115831>

32 Department of Justice Canada, "Bill C-26 (S.C. 2012 c. 9) Reforms to Self-Defence and Defence of Property:

Technical Guide for Practitioners", (Mar. 2013) <https://www.justice.gc.ca/eng/rp-pr/other-autre/rsddp-rlddp/pdf/c26.pdf> (last visited Apr.20, 2026)

33 Vanessa A MacDonnell, The New Self-Defence law: Progressive Development or status Quo?, 304.



байдлыг илүү өргөн хүрээнд үнэлэх боломжтой болсон.³⁴ Тухайн үйлдэл нь үндэслэлтэй, тохирсон эсэхийг тогтооход харгалзан үзэх хүчин зүйлсийн нэг нь "талуудын аль нэг нь зэвсэг хэрэглэсэн, хэрэглэхээр заналхийлсэн эсэх" юм.

Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлд "зэвсэг гэдэгт хүний амь насыг хохироох, гэмтэл учруулах, эсвэл хүнийг заналхийлэх, айлган сүрдүүлэх зорилгоор хэрэглэсэн, хэрэглэх зориулалттай, хэрэглэхээр төлөвлөсөн зүйлийг ойлгоно. Ийм зорилгогүй галт зэвсэг мөн хамаарна"³⁵ гэж заасан байна. Энэ хүрээнд хутга нь зэвсэгт тооцогдоно. Зэвсэг ашигласан заналхийлэл нь талуудыг тэнцвэргүй нөхцөл байдалд оруулдаг.³⁶ Peter Khill-д холбогдох хэрэгт³⁷ хамгаалсан үйлдэл нь тухайн нөхцөл байдалд тохирсон эсэхийг тогтоохдоо "ижил нөхцөл байдалд жирийн хүн юу хийх байсан бэ" гэсэн шалгуураар үнэлдэг ба зэвсэг хэрэглэсэн довтолгоо нь аюулын түвшинг огцом нэмэгдүүлдэг тул аргагүй хамгаалалтын үйлдлийг илүү өргөн хүрээнд тохирсон гэж үнэлэх үндэслэл болдог гэжээ.

Дээрхээс харахад хутга барин довтлох үйлдлийг тулгарсан, бодит довтолгоо гэж үнэлж, аргагүй хамгаалалт хийхээс өөр аргагүй нөхцөл байдал үүссэн гэж үздэг байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Аргагүй хамгаалалтын эрх нь зөвхөн өөрийгөө эсвэл ойр дотны хүнийг хамгаалах хүрээгээр хязгаарлагдахгүй харин бусдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор гуравдагч этгээд хэрэгжүүлэх боломжтой болох нь Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн хөгжлийн явцаас харагдаж байна. Тухайлбал 1926 оны Шүүх цаазын бичгээс эхлэн 2002 оны Эрүүгийн хууль хүртэл өөрийн болон бусдын эрхийг хамгаалах боломжийг тогтвортой тусгаж ирсэн. Харин 2015 оны Эрүүгийн хуулийн анхны найруулгаар уг хүрээг хумьж "өөрийн, ойр дотны хүний" гэж хязгаарлан тусгасан. Энэ нь гуравдагч этгээд бусдын амь нас, эрүүл мэнд, эрх ашгийг хамгаалах боломжийг бүрэн баталгаажуулаагүй сул талтай зохицуулалт байв. Хүний амь нас, эрүүл мэндэд бодит аюул учирсан үед бусдад туслах боломжгүй болсон, нийгмийн хүнлэг ёсны үнэт зүйлсийн эсрэг зүйл болсон гэж эрдэмтэн, судлаачид шүүмжилсэн. Үүнийг 2020 оны нэмэлт, өөрчлөлтөөр дахин өргөжүүлэн "өөрийн болон бусдын" гэж тодорхойлсноор гуравдагч этгээдийн аргагүй хамгаалалт хийх эрхийг олгосон байна.

Мөн аргагүй хамгаалалт хийх эрх үүсэх үндсэн нөхцөл нь хууль бус, бодитой, тулгарсан довтолгоон байх явдал юм. 2015 оноос өмнөх Эрүүгийн хуульд "нийгэмд аюултай халдлага" гэж өргөн хүрээгээр томьёолж байсан бол 2015 оны

³⁴ Ibid (31).

³⁵ Criminal Code (1985), art.2.

³⁶ Peter Dostal, "Self-Defence and Defence of Another", The Criminal Law Notebook, https://criminalnotebook.ca/index.php/Self-Defence_and_Defence_of_Another (last visited Apr.20, 2026)

³⁷ R. v. Khill, 2021 SCC 37, 2 S.C.R. 948 (2021), <https://decisions.scc-csc.ca/scc-csc/scc-csc/en/item/19020/index.do> (last visited Apr.20, 2026)



Эрүүгийн хуульд "хууль бус довтолгоо" гэж зохицуулсан нь аргагүй хамгаалалтын хүрээг тодорхой хэмжээнд хязгаарласан байна.

Аргагүй хамгаалалтын объектив талын үндсэн шинж болох тулгарсан довтолгоог тодорхойлохдоо довтолгоо эхэлсэн, үргэлжилж байгаа эсвэл эхлэх нь тодорхой болсон нөхцөл байдлыг харгалзан үзэж, тухайн этгээдийн амь нас, эрүүл мэндэд бодитой, шууд аюул учрах боломж бүрдсэн эсэх нь ач холбогдолтой байна. Ялангуяа хутга хэрэглэн довтлох үйлдэл нь тулгарсан, бодит довтолгооны хамгийн тод илрэлд тооцогдож, аргагүй хамгаалалт хийх эрх үүсэх үндэслэл болж буйг Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 2022/ДШМ/810 дугаар магадлалд харуулж байна.

Харьцуулсан судалгаанаас үзэхэд Канад Улсад гуравдагч этгээдийн аргагүй хамгаалалт хийх эрхийг хүлээн зөвшөөрдөг. Мөн аргагүй хамгаалалтын үйлдлийг тухайн нөхцөл байдалд тохирсон эсэх, үндэслэлтэй байсан эсэхийг олон хүчин зүйлээр үнэлдэг бөгөөд хутга (зэвсэг) хэрэглэн довтлох үйлдэл нь талуудыг тэнцвэргүй нөхцөл байдалд оруулдаг бөгөөд аргагүй хамгаалалт хийсэн нь үндэслэлтэйд тооцогддог. Иймд хутга хэрэглэн довтлох үйлдэл нь тулгарсан, бодит довтолгоонд хамаардаг байна.

Дүн шинжилгээний хүрээнд сонгон авсан Улсын дээд шүүхийн 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 272 дугаар тогтоолд "...хутга хэрэглэн довтолсон гэмт үйлдлийг өөр хэн нэгэн хүн хөндлөнгөөс таслан зогсоож, аргагүй хамгаалалт хийх эрхтэй" гэж шүүгдэгчийг цагаатгаж шийдвэрлэсэн нь Эрүүгийн хуульд заасан зохицуулалтыг практикт нэг мөр хэрэглэхэд ач холбогдолтой шийдвэр болсон гэж үзэж байна.



НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж:

1. Эрүүгийн хууль, 2002 он.
2. Эрүүгийн хууль, 2015 он.
3. Монгол Улсын дээд шүүхийн зөвлөмж: Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйл / Аргагүй хамгаалалт/-ийг зөв хэрэглэх тухай, 2007 он.

2. Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Батсүхийн Баярсайхан, Суурийн Жанцан, Жамсрангийн Энхнасан, Даваажавын Сумъяацэрэн, *Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911–2009 он)*, 2011 он.
2. Лувсангийн Бат-Очир, *Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги*, 2020 он.
3. Суурийн Жанцан, *Гэмт хэргийн тухай Эрүүгийн эрх зүйн тулгуур ойлголт*, 2005 он.
4. Тогоогийн Золбоо, *Эрүүгийн эрх зүй /Ерөнхий анги/ Гэмт хэргийн бүтээц*, 2023 он.
5. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, 2013 он.
6. Содовсүрэнгийн Нарангэрэл, Жуужаагийн Эрдэнэбулган, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж, 2019 он.
7. Ё.Бямбацэрэн "Аргагүй хамгаалалт уу, хууль ёсны хамгаалалт уу..." *Монголын төр, эрх зүй* 2(84), 2016 он.
8. Г.Эрдэнэчимэг, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх аргагүй хамгаалалт, Хууль зүйн магистрын диссертац*, Монгол Улсын Их Сургууль, 2016 он.
9. Дансрангийн Отгонбаяр, *Аргагүй хамгаалалтын эрүүгийн эрх зүйн зохицуулалт, практик хэрэглээ*, Хууль зүйн магистрын диссертац, Монгол Улсын Их Сургууль, 2024 он.
10. Г.Энхтайван, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх Аргагүй хамгаалалт, Хууль зүйн магистрын диссертац* 2003 он.

3. Гадаад хэл дээрх эх сурвалж:

1. Criminal Code, 1985.
2. Department of Justice Canada, "Bill C-26 (S.C. 2012 c. 9) Reforms to Self-Defence and Defence of Property: Technical Guide for Practitioners", 2013.
3. R. v. Khill, 2021 SCC 37, 2 S.C.R. 948, 2021.
4. Larry C. Wilson, "The Defence of Others – Criminal Law and the Good Samaritan", McGill Law Journal.
5. Vanessa A MacDonnell, The New Self-Defence law: ProgreSSive DeveloPmeNT or STaTuS Quo?, 304.
6. Peter Dostal, "Self-Defence and Defence of Another", The Criminal Law Notebook.

4. Цахим эх сурвалж:

1. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан: <https://shuukh.mn/>.
2. Монгол Улсын дээд шүүхийн цахим хаяг: <http://old.supremecourt.mn/>.



3. Монгол Улсын Их Сургуулийн цахим номын сан: <https://e-library.num.edu.mn/>.
4. Хууль, эрх зүйн бүтээлийн цахим сан: <https://legaldata.mn/>.
5. Канад улсын McGill хууль зүйн сургуулийн эрдэм шинжилгээний хууль зүйн сэтгүүлийн цахим хаяг: <https://lawjournal.mcgill.ca/>.
6. Канад Улсын Засгийн газрын цахим хаяг: <https://www.canada.ca/en.html>.